



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐24 оны 1᠐ сарын 1᠖ өдөр

Дугаар А/324.

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
118 дугаар сургуулийн эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн есдүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 118 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 28,755,501.99 (хорин найман сая долоон зуун тавин таван мянга таван зуун нэг төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг нийслэлийн ерөнхийн боловсролын 118 дугаар сургууль (Б.Хандмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 13 нэр төрлийн 6,068,731.99 (зургаан сая жаран найман мянга долоон зуун гучин нэгэн төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, 15 нэр төрлийн 22,686,770.00 (хорин хоёр сая зургаан зуун наян зургаан мянга долоон зуун далан) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 200,000.00 (хоёр зуун мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 60,000.00 (жаран мянга) төгрөгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг нийслэлийн ерөнхий боловсролын 118 дугаар сургууль (Б.Хандмаа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501122

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/31 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 118 дугаар сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдэрсэн гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлийн санал	XXKK-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Яригч хос	5	ш	1	1,760,000.00	1,760,000.00	1,760,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
2	Зөөврийн компьютер	5	ш	2	1,699,990.00	3,399,980.00	3,399,980.00	-	эвдэрсэн	актлах	5,000	60,000	60,000
3	Процессор	5	ш	1	1,249,990.00	1,249,990.00	1,249,990.00	-	эвдэрсэн	актлах	5,000	10,000	10,000
4	Англи хэлний цахим хэрэгсэл	5	ш	1	170,000.00	170,000.00	170,000.00	-	эвдэрсэн	актлах	1,000	устгах	устгах
5	Утасны оролт /авкон/	5	ш	1	23,100.00	23,100.00	23,100.00	-	эвдэрсэн	актлах	1,000	устгах	устгах
6	Ус цэвэршүүлэгч	5	ш	3	303,233.33	909,699.99	909,699.99	-	эвдэрсэн	актлах	1,000	устгах	устгах
7	Принтер	5	ш	2	469,990.00	939,980.00	939,980.00	-	эвдэрсэн	актлах	5,000	10,000	10,000
8	Хард диск	5	ш	1	495,842.00	495,842.00	495,842.00	-	эвдэрсэн	актлах	1,000	устгах	устгах
9	Зурагт самсунг 42 инч	5	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
10	Дэлгэц 55 инч	5	ш	1	1,950,000.00	1,950,000.00	1,950,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
11	Дэлгэц 24 инч	5	ш	1	620,000.00	620,000.00	620,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
12	Принтер HP	5	ш	1	389,900.00	389,900.00	389,900.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
13	Гадна гэрлэн хаяг	5	ш	1	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5000	5000
14	Өсгөгч	5	ш	1	770,000.00	770,000.00	770,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5000	5000
15	Ус цэвэршүүлэгч	5	ш	2	304,900.00	609,800.00	609,800.00	-	эвдэрсэн	актлах	5,000	устгах	устгах
16	Принтер	5	ш	1	445,740.00	445,740.00	445,740.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
17	Микрофоны ком	5	ш	1	196,900.00	196,900.00	196,900.00	-	эвдэрсэн	актлах	5,000	устгах	устгах
18	Зөөврийн компьютер	5	ш	2	1,699,990.00	3,399,980.00	3,399,980.00	-	эвдэрсэн	актлах	5,000	60,000	60,000
19	Тоос сорогч	5	ш	1	279,990.00	279,990.00	279,990.00	-	эвдэрсэн	актлах	5,000	устгах	устгах
20	Кабель хос	5	ш	1	59,400.00	59,400.00	59,400.00	-	эвдэрсэн	актлах	1,000	устгах	устгах
21	Сүлжээний салаалагч	5	ш	1	3,150,000.00	3,150,000.00	3,150,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	5,000	5,000
22	Тог баригч	5	ш	1	650,000.00	650,000.00	650,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	устгах	устгах
23	Рак 9 / хар хайрцаг /	5	ш	1	580,000.00	580,000.00	580,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	устгах	устгах

24	Хяналтын камерийн бичлэгийн төхөөрөмж	5	ш	1	1,332,000.00	1,332,000.00	1,332,000.00	-	эвдэрсэн	актлах	5,000	10,000	10,000
	Машин тоног төхөөрөмжийн дүн					26,382,301.99	26,382,301.99					195,000	195,000
2.Тавилга эд хогшил													
1	Проекторын хөшиг	5	ш	1	279,200.00	279,200.00	279,200.00	-	эвдэрсэн	актлах	-	5,000	5,000
2	Төмөр шкаф	5	ш	2	387,000.00	774,000.00	774,000.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
3	Роботын сурах бичиг	5	ш	15	8,000.00	120,000.00	120,000.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
4	Мэдээллийн самбар	5	ш	2	600,000.00	1,200,000.00	1,200,000.00	-	эвдэрсэн	актлах	-	устгах	устгах
Тавилга, эд хогшилийн дүн													
Нийт дүн													
	Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө					28,755,501.99	28,755,501.99					200,000	200,000
	Татан төвлөрүүлэх					22,686,770.00							
	Устгах хөрөнгө					6,068,731.99							
	Худалдсанаас олох орлого					200,000.00							
	НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/					60,000.00							